



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 691

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлээр тогтоогдсон, 2 нэрийн, нийт 6,171,101.88 (зургаан сая нэг зуун далан нэгэн мянга нэг зуун нэг төгрөг наян найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 770,631.49 (долоон зуун далан мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах, материалыг ялган тоолж, ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

130602727
29-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дүгээр сарын 12-ны өдрийн
63 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНСАНД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА)-ИЙН ЖАГСАЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, байршил	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Харуулын цэг /Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Элчин сайдын яамны гаднах, зөөврийн, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо/	2007/2018	м2	8	1,508,101.88	343,189.86	1,164,912.02
2	Харуулын цэг /Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Элчин сайдын яамны гаднах, зөөврийн, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо/	2008/2023	м2	8	4,663,000.00	427,441.63	4,235,558.37
	Нийт дүн				6,171,101.88 (зургаан сая нэг зуун далан нэгэн мянга нэг зуун нэгэн төгрөг наян найман мөнгө)	770,631.49 (долоон зуун далан мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг дөчин есөн мөнгө)	5,400,470.39 (таван сая дөрвөн зуун мянга дөрвөн зуун далан төгрөг гучин есөн мөнгө)